

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

### ТАНИЛЦУУЛГА

Энэхүү санал шүүмжийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас боловсруулж, Улсын Их Хурал (УИХ)-д өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний дагалдах хуулийн төсөлд үндэслэн боловсруулав.

Хуулийн төсөлд баяжуулах үйл ажиллагааг хуулиар зохицуулах, уурхайн хаалт, санхүүжилтийн баталгаа бий болгох зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хариуцлагыг нэмэгдүүлж, салбарын хөгжлийг дэмжих зохицуулалт туссан нь сайшаалтай.

Энэхүү санал шүүмж нь газрын хэвлийн баялаг ашиглах үйл ажиллагаанд ил тод байдал, шударга ёсыг хангах, үр өгөөжийг иргэн бүрд тэгш хүртээх, газрын баялаг ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөгүй явуулах, иргэдийн мэдэх эрхийг хангах Үндсэн хуулийн үзэл санаанд хуулийн төслийг нийцүүлэхэд чиглэсэн болно.

### **АСУУДАЛ 1. ИРГЭДИЙН МЭДЭХ ЭРХ ХАНГАГДАХГҮЙ БҮЮУ ЮУ БОЛСНЫГ ӨНГӨРСӨН ХОЙНО НЬ ЗӨВХӨН СОНСГОЛООР МЭДДЭГ БАЙЖ БОЛОХГҮЙ**

Эрдэс баялгийн салбарт өнөөдөр хамгийн тулгамдаж буй асуудал бол авлига, хулгай, төрийн үрэлгэн байдал. Энэ бүхэн нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох, тэгш шударга хүртэх үндсэн зарчим хэрэгжиж чадахгүй байгаагийн гол шалтгаан юм. Өнгөрсөн хугацаанд Ашигт малтмалын тухай хуульд хэдэн арван удаа өөрчлөлт оруулж, бараг танигдахгүй болтол зассан ч байдал дээрдсэнгүй. Ил тод байдал, олон нийтийн хяналтыг хангахгүйгээр “хулгай” дуусахгүй нь илт.

Гэтэл УИХ-аар хэлэлцэж буй Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “ил тод байдал” гэдэг үг хоёр удаа, “нээлтэй байдал” гэдэг үг гурван удаа л оржээ. Тодруулбал, хуулийн төсөлд “хайгуул,

баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаагаа жил бүр нийтэд ил тод мэдээлнэ”, “геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ ил тод нээлттэй байна” гэснээс өөр ил тод байдлыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зохицуулалт тусаагүй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад гарсан томоохон авлига, албан тушаалын хэргүүдийн дийлэнх нь уул уурхайн салбар, тэр дундаа төрийн өмчит компани (ТӨК)-тэй холбоотой. УИХ 2021-2025 онд нийт 12 удаагийн Ерөнхий хяналтын сонсгол хийсний дөрөв нь уул уурхайн салбартай холбогдох бөгөөд өнгөрсөн онд л гэхэд Халзан бүрэгтэй, Оюу толгой төсөлтэй холбоотой сонсголууд болсон билээ.

МУ-ын Засгийн газар 2019 оноос хойш дөрвөн удаагийн шийдвэрээр Эрдэнэс Тавантолгой, Монголросцветмет, Эрдэнэт үйлдвэр, Тавантолгой, Тавантолгой төмөр зам зэрэг компаниудад онцгой дэглэм тогтоож, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн худалдан авалт, борлуулалтын 49 гэрээг ил тод болгосон ч цаана нь бусад ТӨК-иудад хэчнээн гэрээ нууц хэвээр үлдсэн нь тодорхойгүй.

Транспэрэнси Интернэшнл байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын индексээр Монгол Улс 2025 онд арван байр ухарч 124-т эрэмбэлэгдэхэд уул уурхайн салбар, ялангуяа ТӨК-ийн засаглалын үзүүлэлтүүд, сүүлийн жилүүдэд гарсан авлига, хулгайн хэргүүд жин даржээ. Тийм ч учраас авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн үндсэн таван зөвлөмж өгсний хоёр нь уул уурхайн салбар, ТӨК-ийн засаглал, ил тод байдлыг сайжруулахад чиглэж байна.<sup>1</sup>

Тус салбарт амжилттай хэрэгжиж ирсэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) сүүлийн үед эрс суларч, 2022 оны баталгаажуулалтаар “дунд” түвшинд үнэлэгдэх болсон нь ч ийнхүү Авлигын индекс ухрахад нөлөөлсөн нэг хүчин зүйл юм. Уул уурхайн салбарт ил тод байдал ийнхүү суларсан нь ОУИТБС-ыг 2018 онд Ерөнхий сайдын эрхлэх асуудлаас гаргаж, салбарын яаманд шилжүүлснээс эхлэлтэй. Салбарын яам “сайн засаглал, ил тод байдал”-д хэр зэрэг ач холбогдол өгч ирснийг энэ удаагийн хуулийн төсөлд “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх” асуудал бүхэлдээ орхигдсоноос харж болно.

Хуулийн төслийг Үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулах ёстой.<sup>2</sup> Хуулийн төслийн Үзэл баримтлалд “Хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэлийг 2019 онд Монгол Улсын үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлт болохыг дурдаад

<sup>1</sup> Авлигын төсөөллийн индекс 2025, Транспэрэнси Интернэшнл <https://www.transparency.mn/post/%D0%B0%D0%B2%D0%BB%D0%B8%D0%B3%D1%8B%D0%BD-%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D3%A9%D0%BB%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B8%D0%BD%D0%B4%D0%B5%D0%BA%D1%81-2025>

<sup>2</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг.

үүнд “иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэсэн үндсэн хуулийн заалтыг үндэслэл болгон тусгасан байна. Гэсэн хэдий ч ил тод байдлыг хангах тогтолцоо, энэ чиглэлээр төрийн хүлээх үүрэг хариуцлагыг орхигдуулсан нь хуулийн төсөл Үзэл баримтлалдаа бүрэн нийцээгүйг харуулж байна.

*Санал, зөвлөмж: Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд ил тод байдлыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх суурь зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Үүнд:*

- *Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (АҮЭБЯ)-ны чиг үүрэгт ОУИТБС-ыг дэмжин хэрэгжүүлэх үүргийг тусгах,*
- *ОУИТБС-ын мэдээллийн санг Эрдэс баялгийн мэдээллийн сангийн нэг бүрдэл хэсэг болгон хуульчлах,*
- *Мэдээллийн сангийн бүрдлийг тодорхойлж, мэдээлэл тус бүрийг нийлүүлэх талаарх АҮЭБЯ, АМГТГ, ҮГА болон СЯ, БОУАӨЯ, ГБХНХЯ, ТЕГ, орон нутгийн захиргаа зэрэг ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцогч төрийн байгууллагуудын үүргийг нэг бүрчлэн нарийвчлан тодорхойлох,*
- *Төр болон ТӨК-уудын бусад этгээдтэй хийсэн газрын хэвлийн баялагтай холбоотой бүх төрлийн гэрээ ил тод байх, нууцлахыг хориглох заалт тусгах. Тухайлбал, хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ, газрын тосны эрлийн гэрээ, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ, ТӨК-ийн борлуулалтын гэрээ, нөхөн сэргээлтийн гэрээ гэх мэт.*
- *Мэдээллийн санг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар тогтоосон нээлттэй мэдээллийн стандартад нийцүүлэх заалт тусгах,*
- *Тусгай зөвшөөрөл эзэмшигч, тэр дундаа ТӨК-ууд, бичил уурхай эрхлэгчдийн ОУИТБС-ын стандартын дагуу тайлан гаргах үүрэг, хариуцлагыг хуульчлах,*
- *Салбарын засаглал, ил тод байдлын асуудлаар зөвшилцөлд тулгуурласан шийдвэр гаргах олон талт ажлын хэсгийн механизмыг ОУИТБС-ын стандартад нийцүүлэн хуульчлах,*
- *ОУИТБС-ын тайлан, дүгнэлт зөвлөмж, тэдгээрийн хэрэгжилтийг Засгийн газар, УИХ жил бүр дүгнэн хэлэлцэх заалт тусгах.*
- *Аль эсвэл Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг Ашигт малтмалын тухай хуультай хамт хэлэлцэн зэрэг батлах.*

## **АСУУДАЛ 2. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС БҮРЭН СЭРГИЙЛЖ БАЙЖ Л БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ӨГӨӨЖИЙГ ТЭГШ, ШУДАРГА ХҮРТЭХ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗАРЧИМ САЯ ХЭРЭГЖИНЭ.**

Монгол Улсад ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх хууль тогтоомж бий боловч эрдэс баялгийн салбарын бүх шийдвэрийг бүрэн хамарч үйлчилж чаддаггүй. Тухайлбал, хайгуулын тайлан, ордын нөөц, техник-эдийн засгийн үндэслэлийг батлах зэрэг чухал шийдвэр гаргадаг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-ийн гишүүд, шинжээч нар нэгдмэл сонирхолтой этгээдээ тайлагнадаггүй, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг нь ил тод байдаггүй. Учир нь дээрх хуулиудад ЭБМЗ-ийн гишүүн, шинжээч, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комисс, АМГТГ-аас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулдаг олон төрлийн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, ТӨК-д давуу тал олгох, засаглалыг сайжруулах зэрэг энэ салбарын онцлогт тохирч үйлчлэх зохицуулалт байхгүй.

Тэрчлэн Ашигт малтмалын тухай хуульд заасан шийдвэр гаргах процесс тодорхойгүй, зохицуулалтгүй орхигдсон зүйлс оршоор байгаа нь оролцогч талуудад ойлгомжгүй байдал, албан тушаалтнуудад өөрийн үзэмжээр шийдвэр гаргах боломж үүсгэж, тэгш шударга өрсөлдөөнийг хязгаарлаж байна.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн 2023 онд хийсэн “Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ” судалгаагаараа тойм судалгааны хүсэлтийг шийдвэрлэх, талбай ялгах, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах, уулын ажлын төлөвлөгөө, тайлан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн төлөвлөгөө батлах, уурхайн хаалт зэрэг шийдвэр гаргах процесст зохицуулалтын цоорхой, тодорхойгүй байдал оршин байгаа нь авлигын эрсдэл үүсгэж байгааг тогтоожээ.<sup>3</sup> Тухайлбал, Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад сонгон шалгаруулах комиссын эрх, үүрэг, ажиллах горим, бүрэлдэхүүн, томилох процесс нь тодорхойгүй, хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх олон нийт, мэргэжлийн байгууллагын оролцоо байхгүй нь эрсдэл үүсгэж байгааг дурджээ.

Нээлттэй нийгэм форум ТББ-аас 2024 онд гаргасан “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ил тод байдал” сэдэвт бодлогын шинжилгээний тайланд ЭБМЗ нь уул уурхайн төсөлтэй холбоотой хамгийн чухал шийдвэрүүдийг гаргадаг салбарын голлох үүрэг бүхий институтийн нэг атал уг зөвлөлийн томилгоо, бүрэлдэхүүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдал

<sup>3</sup> Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ, 2023 он, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, [https://resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia\\_regulatory\\_assessment\\_corruption\\_risks\\_mining\\_sector\\_mon.pdf](https://resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_regulatory_assessment_corruption_risks_mining_sector_mon.pdf)

хангалтгүй хэмээн дүгнэж, ЭБМЗ-ийн чиг үүрэг, томилгоо, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх шаардлагыг хуульчлах зөвлөмж өгчээ. Тодруулбал, зөвлөлийн гишүүд, шинжээч нь хөрөнгө орлого, хамаарал бүхий этгээдээ тайлагнаж, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг нь тухай бүрд ил тод болгох нь зүйтэй гэж гэжээ.<sup>4</sup>

Тэрчлэн төр засгаас олон нийтэд урьдчилан мэдээлж, хэлэлцүүлэг өрнүүлэхгүйгээр гэнэтийн шийдвэр гаргадаг байдал хэвшил болсон нь хөрөнгө оруулагчдад болгоомжлол төрүүлж байна. Өнгөрсөн хугацаанд Засгийн газрын шийдвэрээр тодорхой ордын тусгай зөвшөөрөл, хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгжийг төрийн мэдэлд авсан боловч хууль зүйн үндэслэл, шийдвэр гаргах үйл явц нь ил тод бус хэвээр байна. Тухайлбал, Салхитын мөнгөний ордод тусгай ажиллагаа явуулж, зөвшөөрлийг нь ТӨК-д шилжүүлсэн, Хөтлийн цемент, шохойн үйлдвэр, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн мэдэлд авсан Засгийн газрын шийдвэрүүд одоо болтол ил тод бус (эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) -д байхгүй) бөгөөд тусгай зөвшөөрөл цуцлах, олгох, шилжүүлэхэд Ашигт малтмалын тухай хуулиар тогтоосон журмыг баримтлаагүй.

2024 онд Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглож, энэ шаардлагыг хангаагүй хуулийн этгээдэд Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч томилох заалт тусгажээ.<sup>5</sup> Засгийн газар бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журам батлах ажлаа одоо болтол хийгээгүйгээс төлөөлөгчийн “бүрэн эрх”-д юу багтаж, ямар ажиллагааг ямар дэгийн дагуу явуулах нь тодорхойгүй хэвээр байна. Өөрөөр хэлбэл, 2025 оны эхээр томилогдсон бүрэн эрхт төлөөлөгч жил гаруй хугацаанд дүрэмгүй ажилласан гэж хэлж болно.

Энэ мэт уул уурхайн салбарт бодитоор оршин буй авлига, ашиг сонирхлын зөрчил, эрсдэл, төр засгийн гэнэтийн оновчгүй шийдвэр, төрийн өмчит компаниудад давуу байдал олгож байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтын орчин, өрсөлдөх чадварыг бууруулж байна.

Гэтэл хуулийн төсөлд энэ мэт эрсдэлийг бууруулахад чиглэсэн зохицуулалт огт тусаагүй. Харин ч хуулийн төсөлд геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ гэх шинэ төрлийн гэрээ бий болгох ба гэрээний агуулга, нөхцөл,

<sup>4</sup> Бодлогын асуудал №49, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ил тод байдал, Нээлттэй нийгэм форум, 2024 он, <https://forum.mn/product/434853>

<sup>5</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16, 9.1.17 дахь заалтууд

үйл явцыг тодорхойгүй үлдээсэн<sup>6</sup> нь авлигын эрсдэлийг улам нэмэгдүүлж байна. Хамгийн гол нь уг гэрээг байгуулсан компанид хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтгүйгээр олгох ба ингэхдээ хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлагыг сулруулсан байна. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл нь Эрдэнэ үйлдвэрт зориулсан АМНАТ-ын тусгай нөхцөл тогтоосон буюу өмчийн төрөл хэлбэрээс хамаарсан ялгаатай байдал бий болгохоор байна. Ийнхүү аль нэг ТӨК-д зориулж, тусгай хууль баталдаг буруу жишиг тогтоож болохгүй. Энэ нь өмчийн бүх хэлбэрийг хүндэтгэн хамгаалах, хууль ижил тэгш үйлчлэх Үндсэн хуулийн зарчимд харш юм.

Иймд энэхүү хуулийн төсөл батлагдсанаар түүний Үзэл баримтлалд тодорхойлсон “Уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин тодорхой болж, бизнес эрхлэх таатай, тогтвортой орчин бүрдэнэ” гэх эерэг үр дүн гарах боломжгүй юм.

*Санал зөвлөмж: Эрэл, хайгуулаас эхлээд, уурхайн хаалт, экспорт хүртэлх бүх шатны шийдвэрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, бизнесийн үйл ажиллагаа дахь төр, хувийн хэвшлийн хоорондох тэгш бус байдлыг хязгаарлах зохицуулалт бий болгох нь зүйтэй.*

- *Төрийн өмчит компанид хуулиас гадуур давуу эрхээр тусгай зөвшөөрөл олгохыг хориглох,*
- *Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг батлахгүй байх.*
- *Тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг ил тод болгож, шийдвэр гаргах үйл явцыг олон нийтийн хяналтад оруулах,*
- *Тойм судалгааны хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх процессыг тодорхой болгож, мэдээ тайлан гаргадаг болох,*
- *Геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах үйл явц, гэрээний агуулгыг хуулиар тодорхойлох,*
- *Геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээт талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгохын өмнө Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу орон нутгаас санал авах шаардлагыг хуульчлах,*

<sup>6</sup> Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг. “151 дугаар зүйл.Геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах”.

- *Хайгуулын талбайн солбицол тогтооход орон нутаг санал өгөх буюу зөвшөөрсөн, татгалзсан хариу өгөх үйл явц, хууль зүйн үндэслэлийг тодорхой болгох,*
- *Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт зарлах хугацааг жил бүр тухайлсан сард эсхүл 3-аас доошгүй сарын өмнө гэх мэтээр тодорхой болгож, гарааны тэгш байдлыг хангах,*
- *Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комисс, уурхай хүлээн авах комисс, ЭБМЗ-ийн гишүүн, шинжээчид тавих шалгуур, томилгоо, тэдгээрийн ажиллах журам, ил тод байдлыг хуульчилж, хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг нээлттэй болгох,*
- *Сонгон шалгаруулалтын комисст иргэний нийгэм, мэргэжлийн байгууллагын төлөөлөл оруулах,*
- *Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх үйл явцыг нарийвчлан зохицуулах, тусгай зөвшөөрлийг сунгахад гэрээний мэдээллийг авдаг байх, гэрээ байгуулаагүй, ил тод болгоогүй нөхцөлд хүлээлгэх хариуцлагыг хуульчлах,*
- *Уулын ажлын төлөвлөгөө, тайлан гаргах үйл явцыг цахимжуулж, тайлан хүлээн авсан, хянасан, хариуцлага тооцсон мэдээллийг ил тод болгох,*
- *Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үйл явцыг нарийвчлан зохицуулж, ил тод байдлыг хангах,*
- *Уул уурхайн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын төлөвлөгөө, дүгнэлт, гарсан үр дүнг ил тод болгох,*
- *Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд чиглэсэн бодлого, удирдамж, заавар боловсруулж, сургалт, бусад арга хэмжээг тогтмол зохион байгуулах асуудлыг тусгах,*
- *Уул уурхайн салбарт хөрөнгө, хувь эзэмшлийн хязгаарлалт тогтоох албан тушаалын жагсаалт гаргах, албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа тухайн хязгаарлалт үйлчлэх хугацаа тогтоох.*

### **АСУУДАЛ 3. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ДАВХАРДСАН ЗОХИЦУУЛАЛТУУДЫГ ЭРГЭЖ НЯГТЛАХ НЬ ЗҮЙТЭЙ.**

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 16-д Ашигт малтмалын тухай хуульд “64<sup>1</sup> дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хамгаалах” гэсэн зүйл нэмж, “Геологи, хайгуул, уул уурхайн олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаанд хууль бусаар халдах, тоног төхөөрөмжийг эвдэх, тээвэрлэлт, үйлдвэрлэлийг санаатайгаар тасалдуулах, уурхайн гарц хаах, цахилгаан, усан хангамжийг зориудаар таслахыг хориглоно” гэсэн заалт тусгажээ.

Энэ заалт нь Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуультай давхардсан, зохицуулалтын нэмэлт ач холбогдолгүй байна. Тодруулбал:

- Эрүүгийн хуулийн 17.8, 17.11, 20.16 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг санаатай болон болгоомжгүйгээр эвдсэн, устгасан, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тогтоосон,
- Зөрчлийн тухай хуулийн 7.12 дугаар зүйлийн 3-т газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг заасан бол, 7.13 дугаар зүйлийн 11-д түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн, 10.27 дугаар зүйлд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан аливаа үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр тус тус заасан болно.
- Зөрчлийн тухай хуулийн 10.27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “ Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалт нэмэхээр тусгасан нь Эрүүгийн хуулийн дээрх заалтуудтай мөн давхардсан байна. Бусдын эд хөрөнгөд санаатай болон болгоомжгүйгээр хохирол учруулж, эсхүл аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулснаас **их хэмжээний хохирол учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулиар зохицуулагдах харилцаа юм. Ийнхүү Эрүүгийн хуулиар зохицуулах асуудлыг Зөрчлийн тухай хуульд давхардуулан тусгах нь хуулийн хэрэглээнд ойлгомжгүй байдал үүсгэж, зүйлчлэлийн алдаа, маргаанд хүргэж болзошгүй.**

Түүнчлэн “уурхайн тээвэрлэлтийг тасалдуулах, гарц хаахыг хориглох” заалтыг хуульчлах нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний үндсэн эрхийн нэг болох тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах эрсдэл үүсгэж болзошгүй. Иймд уг асуудалд маш болгоомжтой хандаж, нягтлан шалгах нь зүйтэй. Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу:

- Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийж,<sup>7</sup>
- Хүний эрхийн үндэсний комиссоос санал авах<sup>8</sup> нь зүйтэй.

Учир нь үүнтэй холбоотой олон улсын туршлагыг харвал, иргэдийн жагсаал, эсэргүүцэл нь тодорхой хэмжээнд саад учруулж байсан ч хамгаалагдсан эрхэд тооцох бөгөөд уг эрхийг хязгаарлахад зохицуулалтын тодорхой байдал нэн чухал бөгөөд хүчирхийллийн хэлбэрт шилжих, гал түймрийн болон яаралтай тусламжийн автомашины нэвтрэх боломжийг хаах гэх мэт бодитой, тодорхой эрсдэл үүссэн тохиолдолд хязгаарлах нарийвчилсан шаардлага тогтоодог байна.

Мөн ижил төстэй хэрэг маргааныг шийдвэрлэсэн олон улсын туршлага, тэр дундаа Европын хүний эрхийн шүүх, АНУ-ын Дээд шүүх, Канад Улсын Дээд шүүх, Германы Холбооны Үндсэн Хуулийн Шүүхийн шийдвэрийг харвал, зам, гарц хаах үйлдэл нь өөрөө шууд хориглогдох үндэслэл болохгүй бөгөөд хүчирхийллийн хэлбэр шилжсэн эсэх, саад, хүндрэл хэр ноцтой байсан болон дэвшүүлж буй асуудал, үзэл санааны ач холбогдлыг харьцуулан үнэлж шийдвэрлэдэг ажээ.

Тайван замаар жагсаал, цуглаан хийх нь Монгол Улсын олон улсын гэрээ, Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрх мөн. Иймд түүнийг хязгаарлах эрсдэлтэй аливаа зохицуулалтыг хуульчлахын өмнө эрх зүйт ёсны дараах шаардлагын дагуу заавал нягтлан шалгах ёстой.

- Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журам гэсэн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгод нийцэх эсэх,
- Хязгаарлалт нь зайлшгүй бөгөөд зорилгодоо тохирсон байх, пропорциональ буюу үндсэн эрхийг аль болох эдлүүлэхийн тулд хамгийн бага түвшинд байх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16-д “Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж заасан нь хүний үндсэн эрхийг хэрэгжүүлэх баталгааг тусгайлсан хуулиар тогтоох үзэл санааг илэрхийлж буй

<sup>7</sup> Хууль тогтоомжийн тухай хууль, 17 дугаар зүйлийн 17.2.4 дахь заалт, “хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх”.

Хууль тогтоомжийн тухай хууль, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг" Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:

- үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;
- ялгаварлан гадуурхаагүй байх;
- хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх”.

<sup>8</sup> Хууль тогтоомжийн тухай хууль, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, “Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссоос .... тус санал авах бөгөөд ажлын 30 өдрийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ”.

хэрэг юм. Иймд Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах үр дагавар бүхий зохицуулалт нь тусгах нь зохистой эсэхийг анхаарах нь зүйтэй.

*Санал зөвлөмж: Хууль тогтоомжтой давхардсан, хүний эрхийг хязгаарлаж болзошгүй дараах зохицуулалтыг эргэж нягтлах:*

- *Ашигт малтмалын тухай хуульд 64<sup>1</sup> дугаар зүйл нэмэх заалт*
- *Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл зэргийг сайтар нягтлан хэлэлцэх*
- *Хуулийн төсөлд Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийж, Хүний эрхийн үндэсний комиссын саналыг авах.*

#### **АСУУДАЛ 4. ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ШИЙДВЭР ГАРГАХААС ӨМНӨ УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭЛ АВЧ, ОРОЛЦОХ ЭРХИЙГ ОРХИГДУУЛЖЭЭ.**

Ашигт малтмалын тухай хуульд 42<sup>1</sup> дүгээр зүйл.Орон нутгийн оролцоо гэсэн зүйл нэмэхээр заасан ч түүнд агуулагдах зохицуулалт нь мөн л хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудтай давхардсан зохицуулалтын ач холбогдолгүй байна.

Энэ нь уг хуулийн төсөл нь түүний Үзэл баримтлалд тусгагдсан хууль зүйн үндэслэл буюу Үндсэн хуулийн 6.2-т заасан мэдэх эрх, УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваар”-ийн 1.1-д заасан “...онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгох” чиглэлд нийцээгүйг илтгэж байна.

Хуулийн төслийн заалт	Хүний эрх, иргэний орон зайг хязгаарлах эрсдэл болон бусад хуулиар нэгэнт зохицуулагдсан байдал
42 <sup>1</sup> .2.1.салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгт оролцох, санал, зөвлөмж өгөх;	Төрийн бодлого, шийдвэр үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зохицуулалт дараах хууль тогтоомжоор нэгэнт зохицуулагдсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Их Хурлын тухай хууль</li> <li>- Хууль тогтоомжийн тухай хууль,</li> <li>- Захиргааны ерөнхий хууль,</li> <li>- Нийтийн сонголын тухай,</li> <li>- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль</li> </ul>

Хуулийн төслийн заалт	Хүний эрх, иргэний орон зайг хязгаарлах эрсдэл болон бусад хуулиар нэгэнт зохицуулагдсан байдал
42 <sup>1</sup> .2.4.холбогдох төрийн байгууллагаас геологи, уул уурхайн салбарын талаар үнэн, зөв мэдээлэл авах;	Иргэдийн мэдээлэл авах, эрж хайх эрх, түүнийг хэрэгжүүлэх үйл явцыг дараах хуулиудаар нарийвчлан зохицуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндсэн хууль,</li> <li>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль,</li> <li>- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах журмын тухай хууль,</li> <li>- Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль,</li> <li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль,</li> <li>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль,</li> <li>- Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйл болон бусад.</li> </ul>
42 <sup>1</sup> .2.5.ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдэгдэх, гомдол гаргах.	Иргэдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хуулийн зөрчлийг арилгуулах өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргах эрх, түүнийг хянан шийдвэрлэх үйл явц дараах хуулиар нэгэнт зохицуулагдсан тул давхардуулах шаардлагагүй. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Захиргааны ерөнхий хууль,</li> <li>- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,</li> <li>- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах журмын тухай хууль,</li> <li>- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,</li> <li>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,</li> <li>- Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль,</li> <li>- Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль,</li> <li>- Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль,</li> <li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад.</li> </ul>

Хуулийн төсөлд хавсаргасан Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан болон Хуулийн төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээний тайлангаар тус тус өгсөн “Ашигт малтмалын хуульд орон нутгийн иргэдийн оролцооны үе шат, хэлбэрийг нарийвчлан тусгах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Санал: Хүчин төгөлдөр хууль тогтоомжтой давхардсан дараах зохицуулалтыг эргэн харж, иргэдийн мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрхийг хангах хэмжээнд дахин боловсруулах. Үүнд:*

- *Ашигт малтмалын тухай хуульд 42<sup>1</sup> дүгээр зүйл нэмэх заалтын зохицуулалтын ач холбогдлыг эргэн нягтлах,*

- *Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол тогтоох, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулахад Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагааг хэрэгжүүлэх заалт хуулийн төсөлд нэмж тусгах.*

## **АСУУДАЛ 5. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫГ СУЛРУУЛАХ ЁСГҮЙ.**

Хайгуулын үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах шаардлагыг хэрэгжүүлэхгүй бол хүрээлэн буй орчин, хүний эрх, амь насанд ч эрсдэл учруулах аюултай гэдгийг Төв аймгийн Заамар суманд хүний амь эрсэдсэн эмгэнэлт явдал бидэнд нотлон харууллаа. Гэтэл хуулийн төсөлд хайгуулын явцад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх шаардлагыг хасахаар тусгажээ. Хайгуулын ажил нь хэдэн мянган га-аар тоологдох том талбайг хамардаг учраас Заамар суманд тохиолдсон шиг бөглөгдөөгүй өрмийн нүх манай орны хаана, хэд байгааг бид хараахан мэдэхгүй хэвээр байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд орон нутгийн тусгай хэрэгцээний газартай давхцуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үр дагавартай заалт тусжээ.<sup>9</sup> Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хуульд заасан нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг хязгаарлахаар байна.

Улам бүр өргөжин тэлэх чухал ашигт малтмалын үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм, засаглалын шаардлагыг чухалчлах болсон энэ цаг үед манай улс хяналт, хариуцлагыг хуулиар сулруулах нь зохимжгүй бөгөөд энэ нь эргээд уул уурхайн салбарын нэр хүнд, хөгжил, хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

*Санал зөвлөмж: Хайгуулын үйл ажиллагаанд тавих байгаль орчны шаардлагыг сулруулсан дараах заалтуудыг хуулийн төслөөс хасах:*

- *Ашигт малтмалын тухай хуулийн 40.1 дэх хэсэгт заасан “байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэснийг “байгаль орчныг хамгаалах” гэж өөрчлөх заалтыг хуулийн төслөөс хасах,*

<sup>9</sup> Хуулийн төслийн 5 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “20”, “болон орон нутгийн” гэснийг хассугай.

- *Ашигт малтмалын тухай хуулийн 22.1.3 дахь заалт буюу “хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах өргөдөлд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан баримт хавсаргах” шаардлагыг хүчингүй болгох заалтыг хуулийн төслөөс хасах,*
- *Ашигт малтмалын тухай хуулийн 25.1.6 дахь заалт буюу “ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хайгуулын ажлын явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн эсэхийг харгалзах” шаардлагыг хүчингүй болгох заалтыг хуулийн төслөөс хасах.*
- *Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.13 дэх заалтаас “20”, “болон орон нутгийн” гэснийг хасах заалтыг хуулийн төслөөс хасах.*

## **АСУУДАЛ 6. ЦАЦРАГИЙН ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГЫГ СУЛРУУЛСАН**

Хуулийн төсөлд цацраг идэвхт ашигт малтмалын тодорхойлолтоос газрын ховор элементийг хасах, улмаар Цөмийн энергийн тухай хуулийг уялдуулан өөрчлөхөөр тусгажээ. Газрын ховор элементийн ордууд нь агуулга, төрлөөсөө хамаараад цацраг идэвхт изотоп агуулах боломжтой. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын зөвлөмжөөр байгуулагдсан Халзан бүрэгтэй орд газарт хяналт шалгалт хийж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсгийн тайланд “Газрын ховор элемент боловсруулах технологи нь их хэмжээний хаягдал үүсгэхээр байна. Үүний дотор цацраг идэвхт хаягдал багагүй хэмжээгээр гарах бөгөөд төслийн үндсэн баримт бичгүүдэд энэ талаар огт тусгаагүй” талаар дурдсан байдаг.

Тус ордын тусгай зөвшөөрлүүд анх Цөмийн энергийн тухай хууль батлагдахаас өмнө анх 2000-2004 онд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон байдаг. Цөмийн энергийн тухай хуулиас өмнө олгогдсон цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг нэг жилийн хугацаанд шинэчлэн бүртгүүлэх, ийнхүү бүртгүүлээгүй бол хүчин төгөлдөр бусд тооцох шаардлагыг Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулиар тогтоосон байдаг. Учир нь цацраг идэвхт ашигт малтмалын үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчин, хүн амыг сөрөг нөлөөнөөс хамгаалахын тулд ердийн ашигт малтмалаас илүү өндөр шаардлага тавьдаг.

Харин тус ордын тусгай зөвшөөрөлд дээрх шаардлага хэрэгжээгүйгээс тусгай зөвшөөрлүүдийг хүчин төгөлдөр бус гэж үзэх нөхцөл бүрдсэн талаар 2025 оны 9 сард зохион байгуулагдсан сонсголын үеэр яригдсан билээ.

Гэтэл Цөмийн энергийн тухай хуулийн шаардлагыг хангаж, тусгай зөвшөөрлийг шинэчлэн авахын оронд зөвхөн нэг төсөл, нэг компанид зориулж газрын ховор элементийг бүхэлд нь цацраг идэвхт ашигт малтмалын тодорхойлолтоос хасах нь байж болшгүй алдаа юм. Сонсголын үеэр танилцуулсан холбогдох төрийн байгууллагуудын илтгэл, шинжээчдийн дүгнэлтэд тус орд нь цацраг идэвхт элемент агуулсан боловч одоогоор цацрагийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй буюу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрээгүй, цаашид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэж, эерэг ба сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоож, сөрөг нөлөөллийг бууруулах сэргийлэх арга хэмжээг тодорхойлох шаардлагатай гэж үзсэн билээ.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 онд хийсэн Монгол Улсын газрын ховор элементийн хэтийн төлөвийн судалгаанд “Газрын ховор элементэд химийн элементүүдийн үелэх системийн 57 дугаартай лантанаас эхлээд 71 дугаартай лютеци хүртэлх лантаноидын бүлгийн 15 элементүүд (La, Ce, Pr, Nd, Pm, Sm, Eu, Gd, Tb, Dy, Ho, Er, Tm, Yb, Lu) тэдгээрээс гадна 39 дугаартай иттри (Y) болон 21 дугаартай сканди (Sc) зэрэг нийлээд 17 элементийг хамааруулдаг.”<sup>10</sup> гээд дараах эдгээрээс дараах элементүүд цацраг идэвхт чанартай хэмээн дурджээ. Үүнд:

- “Лантан (La57) нь цацраг идэвхт чанартай,
- Неодим (Nd60) нь цацраг идэвхт чанар ихтэй,
- Промети (Pm61) нь маш өргөн цацраг идэвхт чанартай,
- Лютеци (Lu71) нь цацраг идэвхт чанартай” гэжээ.<sup>11</sup>

Тэрчлэн дээрх хяналтын сонсголд танилцуулсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны мэдээллийг харвал Монгол Улсын газрын ховор элементийн нөөц бүхий ордуудын 5 нь лантан, неодим агуулсан, 1 орд буюу Хэнтий аймгийн Биндэр, Өмнөдэлгэр суманд орших Цагаанчулуутын ордод уран, тори агуулсан талаар дурдсан байна.

<sup>10</sup> Ашигт малтмал, газрын тосны газар, Монгол Улсын газрын ховор элементийн төлөв байдлын судалгаа, 2025 он, 2 дахь нүүр, <https://mrpam.gov.mn/public/pages/66/%D0%A5%D0%9C%D0%9C%D0%9C%D0%9C.pdf>

<sup>11</sup> Ашигт малтмал, газрын тосны газар, Монгол Улсын газрын ховор элементийн төлөв байдлын судалгаа, 2025 он, 2-3 дахь нүүр, <https://mrpam.gov.mn/public/pages/66/%D0%A5%D0%9C%D0%9C%D0%9C%D0%9C.pdf>

## МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ХОВОР ЭЛЕМЕНТИЙН ОРДУУДЫН НӨӨЦ

#	Тусгай зөвшөөрөл эзэмшигч, дугаар	Ордын нэр	Аймаг, сум	Ашигт компонентийн дундаж агуулга, % г/м <sup>3</sup> /RE <sub>2</sub> O <sub>3</sub> буюу ислийн/	Хүдрийн хэмжээ, тн /В+С зэргээр/	Нөөц, тн /RE <sub>2</sub> O <sub>3</sub> буюу ислийн хэмжээ В+С- зэргээр/	Давамгайлах элемент
1	РЕО ХХК MV-015334 ЭКТУ ХХК MV-020487	Лугийн гол /1982, 1990, 2009, 2013/	Дорноговь, Хатанбулаг	2.67 -2.71	541,316,630	14,519.34	Хөнгөн /лантан, цери, празеодим, неодим, самари, европи, гадолини/
2	Хотгор Минералс ХХК MV-015631	Хотгор /1983, 2002/	Өмнөговь, Цогт овоо	1.26	135,357,200	1,213,700	Хөнгөн /лантан, цери, празеодим, неодим, самари, европи, гадолини/
3	Рзмет ХХК MV-014937 Жи Эс Би Майнинг ХХК XV-007812	Мушгиа худаг /1989, 2010/	Өмнөговь, Мандал овоо	1.37-3.37	25,235,505	365,102.25	Хөнгөн /лантан, цери, празеодим, неодим, самари, европи, гадолини/
4	Монголиан нешнл рийр ийрт корп MV-006911 Монголиан нешнл рийр ийрт корп MV-012335 Монголиан Лантаноиде корпораци ХХК MV-019329	Халаан Бүрэгтэй /1984, 2015/	Ховд, Мянгад	TREO-0.46, Dy-0.01, Ta-0.01, Nb-0.1, Zr-0.30, CREO-0.18  (Tt+Y) <sub>2</sub> O <sub>3</sub> -0.28 Zr <sub>2</sub> O-0.51, (HTR+Y) <sub>2</sub> O <sub>3</sub> -0.08 Nb <sub>2</sub> O <sub>5</sub> -0.07, TREO-0.44	268,175,530.43	1,203,142.64	Хөнгөн, хүнд /лантан, цери, празеодим, неодим, самари, гадали, диспрози, эрби/
5	НАБД ХХК XV-010256 XV-013060	Цагаан чулуут /1953, 2018/	Биндэр, Өмнөдэлгэр	Монацит – 460 г/м <sup>3</sup>	596,701	Монацит – 274.55	Хөнгөн /цери/, уран, тори
6	Гео-инфо ХХК XV-012322	Улаан дал /2015, 2017/	Увс, Завхан	0.164	82,130.4	124.78	Хөнгөн, хүнд /лантан, цери, празеодим, неодим, самари, европи, гадали, терби диспрози, эрби, холми, иттерби/
Нийт					1,056,227,985	3,105,012.09 Монацит – 274.55	

Эх сурвалж: <https://www.parliament.mn/nm/75712/>

Ийм ч учраас Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 -3.1.5 дахь заалтад “цацраг идэвхт ашигт малтмал” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2-т заасан уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг, “цөмийн бодис” гэж цөмийн материал болон цөмийн технологид хэрэглэгдэх уран, торийн бүлийн цацраг идэвхт изотоп, газрын ховор элемент агуулсан бодисыг тус тус ойлгоно гэж заасан байдаг.

Тэрчлэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдуулан боловсруулсан Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагыг арилгах заалт туссаныг онцгой анхаарах нь зүйтэй.

Ердийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн байхыг шаарддаг байтал цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд энэ шаардлагыг тавихгүй гэж үзсэн нь оновчгүй юм. Мөн энэ зохицуулалтыг хийх болсон үндэслэлийг нотлох тооцоо, судалгаа хуулийн төсөлд хавсаргаагүй байна.

Газрын ховор элементийн олборлолт, боловсруулалтын явц дахь хаягдлын менежмент болон цацрагийн хяналт талаарх олон улсын туршлагыг Хавсралтаас дэлгэрүүлж үзнэ үү.

*Санал зөвлөмж: Цацрагийн хяналт, аюулгүй байдлын шаардлагыг сулруулах эрсдэлтэй дараах өөрчлөлтийг батлахгүй байх.*

- *Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2-т “газрын ховор элементүүдээс бусад” гэж нэмэх заалтыг хасах.*
- *Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлахгүй байх.*

## **АСУУДАЛ 7. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧСӨН БАЙНА.**

Хуулийн төсөл боловсруулах үйл явц нь судалгаа, шинжилгээнд үндэслэх, ил тод байдал, олон нийт, ашиг сонирхол нь хөндөгдөх талуудын оролцоог хангах шаардлагад нийцэхгүй байна.<sup>12</sup>

Хуулийн холбогдох судалгааны чанарт өгсөн үнэлгээг ННФ-ын Бодлогын асуудал цувралын №58 дугаараас <https://forum.mn/product/607595> дэлгэрүүлж үзнэ үү.

Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахад Үзэл баримтлал боловсруулахын өмнө тухайн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх бөгөөд түүний үр дүнд үндэслэн Үзэл баримтлал боловсруулах ёстой.<sup>13</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн энэ шаардлага зөрчигдсэн байна. Үүнд:

- Хуулийн төсөлд хавсаргасан Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан нь холбогдох аргачлалын дагуу хийгдээгүй буюу зохих шаардлага хангахгүй байна. Тодруулбал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалыг баримтлаагүй буюу үнэлгээнд сонгон авсан тодорхой хэсгүүдийг аргачлалд заасан шалгуур үндэслэлээр нэг бүрчлэн үнэлж, шийдлийн хувилбарууд гарган хооронд харьцуулан дүгнэх ажиллагааг бүрэн хэрэгжүүлээгүй. Тэр бүү хэл нэг дүгнэлтийг нэг дор долоон удаа давтсан гэх мэтийг харвал, энэхүү судалгаа зохих ёсоор хийгдээгүй, чанарын шаардлага хангахгүй байна.
- Үзэл баримтлал болон хуулийн төслийг дээрх судалгаанд үндэслэн боловсруулаагүй. Энэ нь хуулийн төсөл боловсруулах үйл явцын дарааллыг зөрчиж, хамгийн түрүүнд хийх ёстой үнэлгээг Үзэл баримтлал болон

<sup>12</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 зүгээр зүйлийн 4.1.2, 4.1.3, 4.1.5 дахь заалт.

<sup>13</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.

хуулийн төсөл боловсруулсны нөхөж хийсэн байж болзошгүй. Ийм учраас үнэлгээний дүгнэлт, Үзэл баримтлал, хуулийн төсөл агуулгын зөрүү их байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан олон нийтийн оролцооны шаардлагыг бүрэн мөрдөөгүй байна. Хуулийн төслийг орон нутагт 21 аймагт хэлэлцүүлсэн боловч уур уурхай бүхий сумын иргэд буюу хуулийн үйлчлэлд эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх талуудын саналыг тухайлан авах шаардлагад нийцэхгүй.

Хуулийн төсөл боловсруулах явц дахь ил тод байдал, олон нийтийн оролцооны шаардлагыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар ННФ-ын Бодлогын асуудал цувралын №57 дугаараас <https://forum.mn/product/607594> дэлгэрүүлж үзнэ үү.

Татварыг зөвхөн хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох УИХ-ын бүрэн эрхэд халдах эрсдэл үүссэн байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 14-т “үндсэн ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах, эдийн засгийн ач холбогдолгүй, тодорхой хэмжээний эрдэс, металл ашигт малтмалын нөөц оногдуулахгүй байж болох бөгөөд тус хэмжээг ... Засгийн газар тогтооно” гэжээ.

*Санал, зөвлөмж: Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай. Үүнд:*

- *Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөний үнэлгээг Засгийн газрын аргачлалын дагуу дахин, зохих ёсоор хийх,*
- *Дээрх үнэлгээний үр дүнд тулгуурлан хуулийн төслийг дахин боловсруулах,*
- *Хуулийн төслийг уул уурхай бүхий сумдын иргэдэд урьдчилан танилцуулж санал авах, саналын товъёг бэлтгэж эргэн мэдээлэх. Ялангуяа аймгуудад зохион байгуулсан хэлэлцүүлгийн зар, хөтөлбөр, тэмдэглэл, оролцогчдын жагсаалт, саналын товъёгийг нээлттэй болгох,*
- *Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.14 дэх заалтыг хасах.*

---oOo---

## ХАВСРАЛТ

### Эх сурвалж 1. World Nuclear Association. (2024, April 29). Naturally-occurring radioactive materials (NORM).

[https://world-nuclear.org/information-library/safety-and-security/radiation-and-health/naturally-occurring-radioactive-materials-norm?utm\\_source=chatgpt.com](https://world-nuclear.org/information-library/safety-and-security/radiation-and-health/naturally-occurring-radioactive-materials-norm?utm_source=chatgpt.com)

#### *Газрын ховор элементийн (REEs) цацраг идэвхт эрсдэл*

Газрын ховор элементүүд (REEs) нь химийн шинж чанарын хувьд уран болон торитой төстэй бөгөөд эдгээр радионуклидуудтай хамт орших нь элбэг байдаг. Гол эрсдлүүд нь дараах байдалтай:

- Тори ба урантай хам орших байдал: Монацит (газрын ховор элементийн гол эрдэс) нь 5–12% тори агуулдаг бөгөөд ксенотим нь бага хэмжээний уран болон тори агуулдаг.
- Их хэмжээний хаягдал үүсэх: Газрын ховор элемент үйлдвэрлэх явцад торийн гидроксид болон цацраг идэвхт хар тугалга, радий агуулсан үлдэгдэл хаягдал их хэмжээгээр үүсдэг. Зөвхөн Хятад улсад гэхэд 30,000 тонн байгалийн гаралтай цацраг идэвхт материалын (NORM) үлдэгдэл түр хадгалагдаж байна.
- Дэгдэмхий радионуклидууд: Хятад дахь газрын ховор элементтэй холбоотой нүүрсний үйлдвэрлэлд яндангийн хийн хамт ялгарсан радионуклидуудын хэмжээ нь дэгдэмхий үнсэнд агуулагдаж байсан хэмжээнээс хавьгүй их байсан. Анхны нүүрсэнд агуулагдаж байсан Po-210-ийн 89%, Pb-210-ийн 71% нь агаар мандалд ялгарсан байна.

#### *Менежмент ба хяналтын шаардлагууд*

Эрдэс элсний баяжмал нь 4,000 Бк/кг хүртэлх цацраг идэвхтэй байж болох бөгөөд NORM-ийн ихэнх хэсэг нь эрдэс боловсруулах үеийн хаягдалд хуримтлагддаг.

#### *Гол техникийн хяналтын арга хэмжээнүүд:*

- Тоосжилтыг бууруулах: Циркон болон газрын ховор элементийн эрдсийг олборлох, нунтаглах үед тоосжилтыг багасгах шаардлагатай. Мөн хайлуулах процессын үед цахиурын тоос болон утааг цуглуулах хэрэгтэй бөгөөд эдгээр нь Pb-210, Po-210 зэрэг дэгдэмхий радионуклидуудыг агуулж болзошгүй.
- Хаягдлыг аюулгүй хадгалах: Циркони болон цирконийн үйлдвэрлэлийн явцад үүсэх хаягдал нь Ra-226-ийн өндөр агууламжтай байж болох бөгөөд

гамма цацрагийн эрсдэл үүсгэдэг. Ийм хаягдлыг металл саванд хийж, тусгай зориулалтын агуулахад хадгалах шаардлагатай.

- Радоны хяналт: Металлын уурхайнуудын судалгаагаар радон болон түүний задралын бүтээгдэхүүнээс үүсэх жилийн дундаж үр дүнт тун 7.75 мЗв байсан тул агааржуулалтын систем болон тогтмол хяналт зайлшгүй шаардлагатай.
- Зохицуулалтын ялгаа: 2015 оны байдлаар International Atomic Energy Agency (IAEA) нь NORM үлдэгдлийн менежментийн үндэсний арга барилуудын уялдаа хангалтгүй хэвээр байгааг тэмдэглэсэн бөгөөд улс орон бүрийн стандартууд ихээхэн ялгаатай байгааг онцолсон.

**Эх сурвалж 2. Health Canada. (2013). Canadian guidelines for the management of naturally occurring radioactive materials (NORM).** <https://www.canada.ca/en/health-canada/services/publications/health-risks-safety/canadian-guidelines-management-naturally-occurring-radioactive-materials.html>

Газрын ховор элементүүдийн (REEs) хувьд гол эрсдэл нь хамт орших уран болон торигос үүдэлтэй бөгөөд боловсруулалтын явцад цацраг идэвхт бодисын агууламж нь тусгай урьдчилан сэргийлэх арга хэмжээ шаардлагатай түвшинд хүртэл нэмэгдэж болдог.

Альфа, бетта болон гамма цацрагт хүн аар өртөж болох бөгөөд агаарт дэгдсэн цацраг идэвхт хий эсвэл тоосонцрыг амьсгалах, эсвэл цацраг идэвхт тоосыг залгих замаар дотоод шарлагад өртөж болно.

#### *Менежмент ба хяналтын техникийн шаардлагууд*

Канадын NORM-ийн удирдамжийн үндсэн зарчим нь NORM-д өртсөн хүмүүс нь Канадын Цөмийн Аюулгүй Байдал ба Хяналтын Комисс (CNSC)-оос зохицуулагддаг цацраг идэвхт материалд өртсөн хүмүүстэй ижил цацрагийн хамгаалалтын стандартад хамрагдах ёстой гэсэн зарчим юм.

#### *Гол техникийн шаардлагууд*

- ALARA зарчим: Хэрэв боломжийн арга хэмжээгээр цацрагийн тунг бууруулах боломжтой бол тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Зорилго нь эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсийг харгалзан үзэхийн зэрэгцээ цацрагийн тунг боломжит хамгийн бага түвшинд байлгах явдал бөгөөд үүнийг ALARA (As Low As Reasonably Achievable) гэсэн товчлолоор илэрхийлдэг.
- Ангиллын босго түвшин: Удирдамжид NORM-ийн хөтөлбөрийн ангилал болон босго түвшинг тогтоосон байдаг. Үүнд судалгаа хийх босго түвшин

(investigation threshold), NORM-ийн менежментийн босго түвшин (NORM management threshold), тунгийн менежментийн босго түвшин (dose management threshold), мөн цацрагийн хамгаалалтын менежментийн босго түвшин (radiation protection management threshold) багтана.

- Амьсгалын замын хяналт: Жилийн зөвшөөрөгдөх шингээлтийн дээд хэмжээ (Annual Limits on Intake, ALI) нь мэргэжлийн шарлагад өртдөг ажилтнууд болон нийт хүн амд хоёуланд нь хамаарах бөгөөд амьсгалын замаар авах шарлагыг хянах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.
- Радоны хяналт: Радон нь дотоод шарлагын хамгийн том эх үүсвэр бөгөөд жилд дунджаар 1.0 мЗв тун өгдөг. Радоны менежмент нь өөрийн гэсэн ангилал болон тооцоолсон ажлын хязгааруудтай байдаг.
- Тээвэрлэлт: NORM-ийн тээвэрлэлт нь холбооны тээврийн зохицуулалтын шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд цацраг идэвхт материалын тээвэрлэлтийн хяналтыг CNSC хариуцдаг.

---

**ХУУЛИЙН ШҮҮМЖ БОЛОВСРУУЛСАН:**  
Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын  
хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Монгол Улс, Улаанбаатар хот 14240,  
Сүхбаатар дүүрэг, А.Түдэвийн гудамж-5/3  
Утас: (976) 76113207  
Вэб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)